

## “МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ”

төслийн жилийн үр дүнгийн семинар

2017 оны 9 дүгээр сарын 21-22-ны өдрүүд

Улаанбаатар зочид буудал

“Номын хүрээ” танхим

### Семинарын зорилт:

- Хөгжлийн асуудалд иргэний оролцоог нэмгдүүлэхэд хувь нэмрээ оруулж буй төрийн зүтгэлтэн, судлаачдыг холбон НЭХ-ын талаарх нэгдсэн ойлголтыг бэхжүүлэх
- Монгол улсад НЭХ-ыг бэхжүүлэх төслийн хүрээнд 10 аймагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны туршлагаас хуваалцахад оршино.

### 08.30-09.00 Бүртгэл

### 09.00-09.30 Хурлын нээлт

- ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн
- Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны захирал болон ерөнхий консул Габрелла Спирли
- Дэлхийн банкны суурин төлөөлөгч Жэймс Андерсон

Хурлын нээлт /09.30/

Дэлхийн банкны төслийн багийн ахлагч Марсела Роза хурлыг эхлүүлэн нээлтийн үг хэлэх зочдыг урив.

**ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн:** Өнгөрсөн хугацаанд Монгол улсын Засгийн газраас иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа, НЭХ-ын судалгаа, дэд төсөл гэх зэрэг олон ажлууд хийгдэж байна. НЭХ гэдэг нь Монгол улсын хувьд харьцангуй шинэ ойлголт, шинэ төсөл юм. Гэсэн хэдий ч бид энэ төсөл, энэ ойлголтын хүрээнд нилээдгүй ажил хийх зайлшгүй шаардлагатай болж байна. Бид өнгөрсөн 2 өдрийн хугацаанд Удирдлагын академид Нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт, туршлагын талаар эрдэм шинжилгээний хурал боллоо. Энэхүү ойлголтыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлах, судалгаа шинжилгээнд үндэслэн хийсэн зүйлсээ бусдад тайлбарлан илэрхийлэх нь үнэхээр сонирхолтой зүйл байлаа. Бид энэ хүрээнд ч хангалттай их ажил хийх шаардлагатай байгаагаас гадна Монгол улсын Засгийн газрын зүгээс манай ЗГХЭГ төслийн эрдэм шинжилгээний хурал, жилийн үр дүнгийн семинарын үйл ажиллагаанд бүгдэд нь хамтран ажиллаж байгаа, цаашид ч хамтран ажиллах болно.

**Габрелла Спирли:** НЭХ-ыг сайжруулах, бэхжүүлэх төслийн хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийг төлөөлөн та бүхэнд хандан мэндчилж байна. НЭХ-ын төсөл нь нэн ядуу иргэдийг хамруулах зорилготой байгаа.

**Жэймс Андерсон:** Ховд аймгаас ирлээ, хоцорч ирсэнд уучлаарай. Бид төслийнхөө үр дүнг шалгаж, харахын тулд Ховд аймаг руу яваад ирлээ. Та бүхэн энэ төслийг хэрэгжүүлэхийн тулд маш олон зүйлийг суралцаж байгаа гэж бодож байна. Нэг нь нөгөөгөөсөө суралцах, туршлагаа солилцох, аль хандлага нь илүү их үр дүнтэй байгааг

гол нь гаргаж ирэх юм. Бид ИНБ болон төртэй хамтран ажиллаж байна. Та бүхний цаашдын ажилд өндөр амжилт хүсье.

### **09.30-10.15 Танилцуулга**

Семинарт оролцогчдыг өөр хооронд нь танилцуулахын тулд Bingo box танилцуулгын хуудсыг тарааж өгч богино хугацаанд олон хүний дэлгэрэнгүй мэдээлэл авч түүнийг баталгаажуулан гарын үсэг зуруулж цуглуулах үйл ажиллагааг явуулав. Энэхүү танилцах үйл ажиллагаа нь 15 минутын турш үргэлжлэв. Үр дүн нь хамгийн олон гарын үсэг зуруулж, мэдээлэл цуглуулж чадсан 4 хүн байв. Кристина Акийно 2 өдрийн турш үргэлжлэх “Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төслийн жилийн үр дүнгийн семинар”-ын хөтөлбөрийг танилцуулав. Семинарт оролцогчдоос энэхүү 2 өдрийн турш хүлээж байгаа талаар асууж, баг бүр 3 минутын турш ярилцаад 1 минутын танилцуулга хийв.

**4-р баг:** НЭХ гэдэг нь засаглалын үйл ажиллагаа, төрийн шийдвэрт түшиглэсэн үйл ажиллагаа нь хэрхэн хэрэгжиж байна, түүний үр дүнгийн загварыг хэрхэн гаргах талаар санал бодлоо солилцох,

**5-р баг:** Төслийн тогтвортой байдлыг хангахад юу анхаарах, цаашид ямар үйл ажиллагаа явуулахад юуг анхаарах вэ гэдэг талаар,

**8-р баг:** Бусдын туршлагаас суралцах,

**6-р баг:** Шийдвэр гаргагчдийн түвшинд иргэдийн оролцоог хангах, иргэдийн дуу хоолойг хэрхэн хүргэх, бусад аймгуудын туршлагыг хуваалцах,

**3-р баг:** Өнөөдөр төсөл хэрэгжиж эхэлж байгаа үе биш хэрэгжээд үр дүн гарчихсан байгаа учраас бие биеээсээ туршлага судлах, хуваалцах, цаашдын хийх үйл ажиллагааг хамтран ярилжаж,

**2-р баг:** Цаашид хэрхэн тогтвортой байх, сайн туршлагаудтай саналаа солилцох.

Д.Амарбаясгалан семинарын ерөнхий агуулга, модулийн хэлбэрийг танилцуулав. Үүнд:

1. НЭХ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ
2. Өгөгдлийг нотлох баримт болгон ашиглах нь
3. Бодлогын өөрчлөлтөд нөлөөлөх нь

Өөрсдийн аймгуудын туршлагыг бусадтайгаа хуваалцахаас гадна бусад туршлагаа солилцох бөгөөд, цаашид юу хийх, ямар арга хэрэглэх талаар мэдээлэл өгөх болно.

10.15-10.30 Цайны завсарлага

### **Модуль 1. Нийгмийн эгэх хариуцлагын хяналт-шинжилгээ, үнэлгээ**

**ХЭСЭГ 1.1. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ /10.45-11.15/**

Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимийн багш доктор М.Амартүвшин “Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн ойлголт”-ын талаар 30 минутын тайлбар, лекц хийв. Мөн Пүрэвтогтох 10 минутын нэмэлт тайлбар хийв.

Семинарт оролцогчид мэдээлэл хийсэн багш нараас асуулт асууж, хариулт авав. Асуулт, хариултын үйл ажиллагааг Д.Амарбаясгалан удирдан явууллаа. Үүнд:

**Асуулт 1:** Төрийн байгууллагын зорилтот түвшинг тодорхойлоход ХШҮ хамгийн чухал ажил байдаг. Энэ талын ойлголт өгсөнд маш их баярлалаа. Эгэх гэдэг үгэн дээр шүүмжлэлтэй хандаж байна. “р” үсэг хаясан байна гэх мэтчилэн байна. Тайлбарлана уу? 2/. Шалгуур үзүүлэлт дээр анхаарах хэрэгтэй байна. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхэд гарсан ХШҮ-ний хуудас нь хэт их хүндрэлтэй байна. Зарим нэг шалгуур үзүүлэлтийг хасах, эсвэл засах шаардлага байна.

**Асуулт 2:** Өнөөдөр хяналт-шинжилгээ, үнэлгээ ямар түвшинд байна вэ? Төрийн болон ТББ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байна уу?

**М.Амартүвшин:** Төрийн болон ТББ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байгаа. ЗГХЭГ-аас гаргасан заавар зөвлөмжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийдэг. Тухайн жилд хяналтандаа авсан үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийдэг. Аймгийн хэмжээнд 3 хүн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийдэг нь бүх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх хүний нөөцийн боломж хангалтгүй байдгаас гадна төсөв санхүүгийн хувьд ч хүндрэлтэй байдаг. Мөн орон нутагт хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийхдээ хөндлөнгийн /өмнө нь энэ ажлыг хийж байсан хүмүүсээр/ гишүүдээр гүйцэтгүүлэх тал байдаг. Зөвхөн 2017 онд журам гарснаар энэ ажил хийгдээд байгаа юм биш, өмнө ч мөн хийж байсан ажил юм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хөндлөнгөөс гүйцэтгүүлэх тохиолдол байдаг. Үүнээс гадна Пүрэвтогтохын тайлбар дээр нэмэлт зүйл хэлье. 10 ажилд 10 хүн оролцсон амжилттай гэсэн байгаа боловч ингэснээр ямар үр дүнд хүрсэн бэ гэдэг нь дутуу байгаа юм. Тэгэхээр хамгийн гол зүйлээ дутуу хийгээд, дутуу тайлбар оруулаад байх шиг байна. Эцсийн дүнд төр болон ТББ-ын хийж байгаа ажлын үр дүн амжилттай, сайн үр дүнтэй, зорилгоо биелүүлсэн байгаасай гэж боддог. Үүнээс гадна сар, жил, улиралд шинжилгээ хийх индикаторыг ялгаж байх хэрэгтэй юм.

**Пүрэвтогтох:** Шалгуур үзүүлэлтийг төсөл, үйл ажиллагаа эхлэхэд л хэмжиж болохуйц, маш ойлгомжтой байхаар сонгож өөрсдөөсөө эхэлж ашиглан, дараа дараагийн үйл ажиллагаандаа ашигшлах хэрэгтэй. Ингэснээр бид хүнд, нүсэр шалгуур үзүүлэлтээс ангижрах болно.

**Кристина Акийно:** Бид шалгуур үзүүлэлтийн талаар нилээд ярилцлаа. Шалгуур үзүүлэлтийг хамгийн гол нь өөрсдөө ашиглаж, хэрэглэж өөрийн болгосон байх хэрэгтэй юм.

**ЗГХЭГ-ийн төлөөлөл:** Эрх зүйн орчинд хяналт-шинжилгээ, үнэлгээний энэхүү баримт бичгүүд мөрдөгдөж байгаа. Нэг талаас ТББ байгаа хэдий ч нөгөө талдаа төр байгаа юм. Төрийн зүгээс хамгийн гол нь гарц дээр анхаарал хандуулдаг бөгөөд үр дүн, үр дагаврыг чухалчилж үздэг. Тэгэхээр бид шалгуур үзүүлэлтийг сайжруулахын тулд тайланд тусгах, ямар арга хэмжээ авах нь зүйтэй талаар тусгах нь зүйтэй юм. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авахдаа хүнд хамгийн ойлголомжтой, энгийн байхаар Дэлхийн банктай хамтран боловсруулж байна.

**Д.Амарбаясгалан:** НЭХ гэдэг үгийн тайлбарыг бид маш олон удаа, үйл ажиллагаа болгон дээрээ тайлбарлаж байгаа. Бид энэхүү семинарт оролцогчдод тарааж өгсөн “Нийгмийн эгэх хариуцлагын тухай, ойлголт”, “Нийгмийн эгэх хариуцлагын аргачлал” гэсэн хоёр гарын авлагатаа маш дэлгэрэнгүй байдлаар тайлбарласан байгааг уншиж танилцаарай. Одоо кейс дээр дасгал ажил хийхийн тулд багт хуваагдья. Материал

тараагдаж өгөв. Одоо 11.50 цаг болж байгаа бөгөөд бүгд дасгалаа ажиллана. Дасгал ажиллах хугацаа 30 минут буюу 11.50-12.20 хүртэл ажиллацгаая.

### **11.15-14.30 Дасгал ажил**

Кейс 1. Малави улс. Эрүүл мэндийн байгууллагын үр нөлөөний кейс байгаа.

Кейс 2. Филиппин улс. Боловсролын талаарх үр дүнгийн кейс байгаа.

Кейс 3. Өөрийгөө үнэлэх аргын талаарх кейс байгаа.

Кейс бүрийг 2, 2 багт тараан өгч, багууд кейс тус бүрт өгөгдсөн 4 асуултын хариултыг цаасан дээр буулгаж, багийн 1 гишүүн тайлбарлана.

**Аймаг тус бүрийн дэд төслийн жишээг танилцуулах удирдамж.** Дэд төслийн үр дүнг богино хугацаанд, оновчтой шинэлэг байдлаар танилцуулах үүднээс телевизын “Shark Tank” нэвтрүүлгийн жишээг оролцогчдод Scrub Daddy-ийн цэвэрлэгч бүтээгдэхүүний талаарх 7 минутын видео бичлэг үзүүлэв.

**Кристина Акийно:** Scrub Daddy-ийн сурталчилгаанд тоглож буй залуу маш богино хугацаанд бүтээгдэхүүнийхээ үр ашгийг тайлбарлаад баримт нотолгоотойгоор тайлбарлаж маш их хэмжээний санхүүжилтийг авч чадсан. Санхүүжилтээрээ юу хийхийг мөн богино хугацаанд хурдан тайлбарлаж чадсан юм. Тэгэхээр бид МАСАМ-ыг мөн ийм болгох гээд байгаа бөгөөд та бүхэнд ийм чадвар эзэмшүүлэх юм. Дэд төсөл болгонд 5 минут олгогдох бөгөөд хийж байгаа зүйлээ маш товч, тодорхой тайлбарлахдаа баримт нотолгоо ашиглан тайлбарлана. Өдрийн хоолны дараагаар баг тус бүрийн тайлбарыг сонсьё.

### **12.45-13.45 Өдрийн хоол**

**Кристина Акийно:** За одоо баг бүр өөрсдийнхөө танилцуулгыг хийж эхэлье. Баг бүрт 10 минутыг танилцуулгыг хийнэ. Төсөлд хамрагдсан 10 аймгийн төслийн танилцуулгыг эхлүүлэе. Өнөөдөр бид 5 аймгийн, маргааш 5 аймгийн танилцуулгыг сонсьё. Ховд, Өвөрхангай аймгийн багийнханыг урьж байна.

**Аймгуудын дэд төслийн танилцуулга:** “Олон нийтийн оролцоот сургууль” Ховд аймгийн Мянгад сумд хэрэгжүүлсэн төсөл. Ховд аймгийн боловсролын салбар дахь НЭХ-ын үйл ажиллагааг багийн 8 гишүүн танилцуулав. Багийн ажлыг телевизийн нэвтрүүлэг хэлбэрээр зохион байгуулсан. Мөн Ховд аймгийн Мянгад сумын ЕБС-ийн дотуур байрны засвар үйлчилгээ хийсэн талаарх видео бичлэгийг үзүүлэв.

**Ховд аймгийн ЕБС-ийн захирал:** Манай аймгийн ЕБС-ийн дотуур байрны асуудал үнэхээр хүндрэлтэй байсан учраас бид бүгд санал нэгтгэйгээр төслийн хүрээнд зохион байгуулсан байгаа юм. Зорилго нэгтгэйгээр төр, лхувийн хэвшлийн хамтын хөдөлмөрөөр бүтээлч үйл ажиллагааг хийж болдог гэдгийг харуулж байгаа юм.

**Өвөрхангай аймгийн төлөөлөл:** Манай Өвөрхангай аймагт аавуудын оролцоотойгоор сургуулийн үйл ажиллагаанд хамтран оролцох төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Өвөрхангай аймгийн дэд төслийн хүрээнд дууны шүлэг зохиогдсон байгаа.

**Кристина Акийно:** Танилцуулга хийсэн багийнханд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** За одоо дасгал ажил руугаа орцгооё. Нийт 3 төрлийн кейс дээр ажиллах дасгал ажил байгаа бөгөөд удирдамжид тусгагдсан 4 асуултад 2 баг хамтран 10 минутын дотор хариулт өгье.

Баг тус бүр удирдамжид тусгагдсан доорх 4 асуултад хариулсан.

- Үнэлгээ хийсэн гол аргачлал юу вэ?
- Үнэлгээ хийх болсон зорилго юу вэ? тухайн салбарын мэдлэг туршлагыг нэмэгдүүлэхэд үнэлгээ хийсэн явдал хэрхэн нөлөөлсөн бэ?
- Үнэлгээний энэхүү аргачлалын давуу тал юу байсан бэ?
- Энэхүү аргачлалаар үнэлгээ хийхэд ямар хүндрэл гарсан бэ?

**1-р багийн танилцуулга.** Өөрийгөө үнэлэх кейс дээр ажилласан. /III баг 3-3/

1. Үнэлгээ хийсэн аргачлал.
  - АЭОШ (1/. Ажиглалт, 2/. Эсэргүүцэл, 3/. Ойлголт, 4/. Шийдвэр)
2. Зорилго юу вэ?
  - “Ногоон навч” хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох.
  - Тухайн салбарын мэдлэг туршлагыг нэмэгдүүлэхэд үнэлгээ хийсэн явдал хэрхэн нөлөөлсөн бэ?
    - Төслийн талаар зохицуулагч өөрөө өөрийгөө үнэлнэ.
    - Оролцогчдыг зөв чиглүүлж, системтэй нэгдсэн ойлголтод хүргэх.
3. Үнэлгээний аргачлалын давуу системтэй бүтэцтэй (АЭОШ) тал?
  - Аргачлалынхаа бүтцэд өөрчлөлт оруулах байдлаар нөлөөлнө
  - Төслийн үр нөлөөгөөр ажигласан зүйлээ ангилан ялгаж болно.
  - Оролцогчдын анхаарлыг нэг зүгт хандуулах, өөрчлөлт гаргаж болох талаар “ХАМТЫН ШИЙДВЭР” гаргана.
4. Энэ аргачлалаар үнэлгээ хийхэд ямар хүндрэл гарсан бэ?
  - Оролцогчид сэдвээсээ халих,
  - Хугацаа алдах,
  - Өөртөө итгэлгүй байх.

**2-р багийн танилцуулга.** Малави улсын үр нөлөөлийн кейс дээр ажилласан танилцуулга. /Малави/

1. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ.

Давуу тал: Төрийн захиргааны шалгуур үзүүлэлт бүх оролцогч талын оролцоотойгоор боловсруулагдаж, хэрэгжүүлэгдэж хянасан.

ЯДЯ – ялган дахь ялгаа. Харьцуулалтын арга хэрэглэн сэтгэл ханамжийн судалгааг “ИОК”-иргэдийн онооны картаар хэмжсэн.

2. Төслийн хэрэгжилтийн мэдээлэл дээр үндэслэн “ИОК”-аар нэмэлт нэмэлт мэдээлэл цуглуулж үр дагаврыг хэмжиж амжилт, сул тал, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.
3. Давуу тал (DiD)  
Давуу тал - явцын үнэлгээ 6 сар тутам хийгдэж, шаардлагатай сайжруулалт хийгдсэн.

**3-р багийн танилцуулга.** Филиппин улсын боловсролын талаарх үр дүнгийн кейс дээр ажилласан танилцуулга.

1. Үнэлгээ хийх болсон зорилго:
  - БСУ-н орчин нөхцөл, дэд бүтэц
  - Сургалт
  - Салбар хоорондын уялдаа холбоо
  - Бүх асуудал, гүйцэтгэлийг сайжруулах.
2. Үнэлгээ хийсэн гол аргачлал?
  - Тулгамдсан асуудал “МСШ” – онлайнд ил тод байршуулсан.
  - БГ-ын мэдээлэлд анализ хийсэн (ИНБ, эцэг эх, сурагчид, сайн дурынхан, багш, ажилчид боловсролын байгууллага).
3. Давуу тал:
  - Богино хугацаанд олныг хамарсан,
  - “МСШ” – Фэйсбүүк
  - Улс орон даяар хэрэгжсэн
  - Сайн мэдээлэлтэй иргэдийн шаардлага зөв шийдвэр гаргахад нөлөөлсөн.
4. Хүндрэл
  - Суурьшлын тархай бутархай байдал,
  - БГ-ын нөөц чадавхи,
  - Улс төрийн тогтворгүй байдал,
  - Мэдээлэл авахад хүндрэлтэй төрлийн түвшинд мэдээлэл салангид тархай, бутархай.

**Д.Амарбаясгалан:** Кейс дээр ажиллаж, танилцуулга хийсэн 3 багтаа маш их баярлалаа, багууд маш сайн уншиж, танилцаж, ойлгосон байна гэж харагдаж байна. Үнэлгээ хийх өөр өөр аргууд байгааг кейс дээрээс ажиглаж хараасай гэж байгаа юм.

Өөрийгөө үнэлэх – өөрийгөө үнэлэх

Малави – үр нөлөөний үнэлгээ

Филиппин – outcome mapping буюу гарсан үр дүнг тодорхойлох/нэгтгэх

Ямар ч аргыг хэрэглэсэн гэсэн хамгийн гол нь үр дүн чухал бөгөөд захиалагч нь юу хүсч байна, түүнд тохирсон аргыг хэрэглэх юм.

**ХЭСЭГ 1.2. ЭСЭРГҮҮЦЭН ДҮГНЭХ БА СУРАЛЦАХ АРГА ЗҮЙ /14.40-16.30/**

**15.10-15.30 Цайны завсарлага**

Хэнтий аймгийн “Олон нийтийн оролцоотой төсвийн хяналт” дэд төслийн танилцуулгыг 4 хүний бүрэлдэхүүнтэй баг хийв. Танилцуулгыг тайлбар байдлаар 3 гишүүн хийлээ.

**Кристина Акийно:** Танилцуулга хийсэн Хэнтий аймгийн багтаа баярлалаа. Одоо Хөвсгөл аймгийн багийг урьж байна.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, хувь нэмрээ оруулах дэд төслийн танилцуулгыг 3 хүн хийв. Төслийн үр дүнг зураг үзүүлэн тайлбар хийлээ.

**Кристина Акийно:** Бид аливаа ажлыг хийхэд хөшүүрэг хэрэгтэй. Баярлалаа. Сүхбаатар аймгийн дэд төслийн багийг урьж байна.

Сүхбаатар аймгийн “Өсвөр насны хүүхдийн шүдний өвчлөл” дэд төслийн танилцуулгыг 3 гишүүн танилцуулав. Манай дэд төсөл нь Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ аймагт хэрэгжүүлж байгаа. Энэ төслийн танилцуулга 9 дүгээр сарын 26-нд төрийн ордонд хийгдэх тул та бүхэн хүрэлцэн ирж танилцаж болно.

**Пүрэвтогтох:** Одоо дасгал ажилдаа орё. Та бүхнийг аймаг аймгаар нь хуваасан бөгөөд төслийн баримт бичигтээ тусгасан НЭХ-ын 3 үндсэн үр дүнгээ хэрхэн тусгаснаа тарааж өгсөн цаас тус бүр дээр бичиж байршуулна.

- Бид юуг тусгасан бэ?
- Бид юуг тусгаж болох байсан бэ? гэсэн 2 асуултад хариулах ба ингэхдээ бусад аймгуудад туршлага хуваалцахуйц байдлаар бичнэ. Энэ даалгаврын үргэлжлэх хугацаа 20 минут байна.

#### ***Дасгал ажлын танилцуулга:***

**1/. Говьсүмбэр аймаг:** Манай аймагт Сүрьеэг бууруулах төслийг хэрэгжүүлсэн. Хамгийн гол нь иргэд, ИНБ-ын оролцоог хангах зорилгоор бичиг баримтыг боловсруулсан. Эмч, эмнэлэгийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, эмнэлэгийн байр барих гэсэн зорилтуудыг тавьсан. Бид аймгийн хэмжээнд НЭХ-ын тухай ойлголтыг нийт иргэддээ хийж чадаагүй хэдий ч үүнийг цаашид хийе гэж бодож байгаа.

#### **2/. Говь-Алтай аймаг:**

Бид 3 үр дүнг тодорхойлсон.

1. Иргэд, ИНБ-ууд, төрийн байгуулагууд хамтран ажиллаж чадсан.
2. Сайн сургуулийн дэмжих аргачлалыг бий болгосон.
3. 2 дахь үр дүнг хийснээр иргэдэд таниулах, түүнийг дэмжих аргачлалыг олж авсан.

Хамтран ажиллахад бие биенээ маш сайн ойлголцож байсан. Зарим нэг сул талууд гарч байлаа. Үүнд:

- Дэд төсөл 4 дүгээр сард бус 1 дүгээр сард эхэлсэн бол илүү үр дүнтэй, зуны амралт, сонгуулийн үйл ажиллагаанд шахагдахгүй байх байсан.
- Сургалт 9-р сард хийгдсэн бол илүү олон хүмүүсийг хамруулах боломжтой байсан.
- Иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдал гэж 15 хоног хязгаарлагдсан.

#### **3/. Хэнтий аймаг:**

Үр дүн:

1. Гурван талт гэрээг олон нийтийн оролцоотой үнэлдэг болсон.
2. Дээрх үйл ажиллагааг ИТХ, ЗДТГ, ЭМГ, ӨЭМТ, ИНБ, иргэд хамтран ажиллах тулгамдсан асуудлаа шийдэж байна. Харилцан ойлголцсон.
  - Санхүүжилт /түр оршин суугчдын асуудал, хугацаа, нийгмийн эрүүл мэндийн байгууллага сум - ӨЭМТ/
  - Бүтэц орон тоо
  - Орчны тохижилт

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэж чадсан.

#### **4/. Өвөрхангай аймаг:**

*Юуг хамгийн сайн хийсэн бэ?*

- Хэрэгжилтийн баг сайн ажилласан,
- 10 загвараа сайн боловсруулж, төлөвлөлтөө сайн хийсэн,
- Хамтын ажиллагаа, түншлэлийг сайн хийсэн,
- Хөндлөнгийн хяналт хийх загваруудтай болсон,
- Чанарын стандарт үнэлэх арга зүйд суралцсан.

*Юуг сайжруулах байсан бэ?*

- Иргэдэд өгөх мэдээлэл, мэдлэг дутмаг,
- Бусад төрийн байгууллагуудад ойлгуулах байдал дутмаг,
- Удирдлагууд, шийдвэр гаргагчид жигд ойлголтгүй, бид богино хугацаанд бүрэн нөлөөлж чадаагүй.

*Сайн тал:*

1. ОНОС-ын загваруудыг 10 сургуульд бий болгосон.
2. Сургуулийг олон нийтийн оролцооны төв гэдгийг хүлээн зөвшөөрч, хамтран ажиллах сонирхолтой болсон нь хандлагын өөрлөлтийг хийж чадсан гэж үзэж байна. Асуудлыг шийдвэрлэсэнээр хамтран ажиллах боломжтой болсон.
3. Эрх зүйн асуудлуудыг шийдвэрлэж, эрх зүйн баримт бичигтэй болсон.

#### **5/. Дорнод аймаг:**

- Эмнэлэгийн ажилтны үйлчилгээний стандартыг сайжруулсан.
- 1 ширхэг зөөврийн рентген аппараттай болсон.
- Бид нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох төвтэй болсон, үүнийг баталгаажуулаагүй байгаа.
- Гарын хээний 3 ширхэг аппаратыг суурилуулж ажиллуулж байна.

#### **6/. Сүхбаатар аймаг:**

Өсвөр үеийнхний шүдний өвчлөл тулгамдсан асуудал гэдгийг хүн бүрт маш сайн ойлгуулж, мэдээллийг хүн бүр мэддэг болсон.

*Сайн тал:*

- ИОК-ыг бүрэн ашиглах чадвар эзэмшсэн.
- Төр, ИНБ-ын хамтын ажиллагаа сайжирсан.
- Хүүхдийн шүдний кабинеттэй болсон
- Мэдээллийг маш сайн хүргэсэн.

*Сул тал:*

- Цаг хугацааны хувьд хангалтгүй байсан боловч тодорхой зорилтуудыг гүйцэтгэсэн.
- Цаг хугацааны хувьд хүүхдийн хичээлийн жилийн амралт таарсан.
- Мэдээллийн тархалтын Филиппин улсын жишгээр түгээх шаардлагатай байв.

#### **7/. Увс аймаг:**

Энэхүү төслийн хүрээнд хийсэн ажил:

- Эмийн хэрэгцээ тооцсон,



- Иргэдийн оролцоот хяналт,
- Гэрээний хэрэгжилтэд хяналт хийснээр эгэх хариуцлагыг дээшлүүлсэн,
- Хамтын ажиллагаа өргөжсөн.

Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнгүүд гарсан.

- Үр дүн 1. ОНОК-аар тусламж, хангамжийг судалсанаар суурь мэдээлэл гарч төлөвлөлт хийсэн.
- Үр дүн 2. Эмийн тасалдал 12.9 хувь буурч, эм эмнэлэгийн хэрэгслийн хангамж нэмэгдэж, урвалж оношлуурын хангамж 2 дахин нэмэгдэж, оношлогооны чанар хүртээмж сайжирсанаар иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн.
- Үр дүн 3. ЭЭХХАА-ны тендерийн үйл ажиллагааг боловсронгуй болгосон, ТТЖБ-т өөрчлөлт оруулсан.

*Сайн үр дүн:* - Суурь үнэлэлтийг зөв хийснээр

- Төсвийг 2 дахин хэмнэсэн
- Тендерийн бичиг баримтыг боловсруулалтыг сайжруулсан.

*Сул тал:* - Удирдлагууд, шийдвэр гаргагчдад хангалттай хэмжээгээр нөлөөлж чадаагүй,

- Иргэдэд НЭХ-ын талаар мэдээлэл хангалттай хүргэж чадаагүй,
- Хамтын ажиллагаа бий болсон хэдий ч иргэдийн НЭХ-ын талаарх мэдээлэл думтаг байсан.

#### **8/. Ховд аймаг:**

- Иргэдийн оролцоог бий болгосон,
- Хяналтын тогтолцоог сайжруулсан
- Бодлогын баримт бичиг
- Сургуулийн үйл ажиллагаа сайжирсан

Бид зорьж байсан боловч амжаагүй хэд хэдэн ажил байгаа боловч үүндээ хүрнэ гэж бодож байгаа

#### **9/. Хөвсгөл аймаг:**

Иргэдийн оролцоог сайжруулахыг зорьсон. Иргэдийн сэтгэл ханамж нь суурь – 23 хувь байсныг 53 хувь болгосон, явц 48 хувьтай байсан бөгөөд ахиц 30 хувь байлаа.

- 1) Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжсэнээр иргэдтэй цахимаар холбогдсоноор хүлээгдэл чирэгдлийг 40 хувиар бууруулсан.
- 2) ИНБ-аас өгсөн зөвлөмжийг үр дүнтэй болгохын тул 2 бодлогын бичиг баримт гаргасан.
- 3) Мэдээлэл, сурталчилгааг маш сайн хийж, ил тод нээлттэй байдлаар үйл ажиллагааг явуулсан.
- 4) Сургалтад иргэд 267, эмч мэргэжилтэн 787 давхардсан тоогоор хамрагдсан.
- 5) Иргэдэд НЭХ-ын талаарх мэдээллийг хүргэсэнээс facebook-ээр 880, youtube-ээр 163 удаа хандалттай байв.
- 6) Түр оршин суугчдын эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй.

7) Нийгмийн эгэх хариуцлага гэх ойлголтыг иргэдэд бүрэн дүүрэн өгч чадаагүй.

***ДҮГНЭЛТ, ХААЛТ /16.30-17.00/***

**Пүрэвтогтох:** Энэ бүх танилцуулгаас харахад зарим аймгууд маш сайн шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан байна. Төслийн тогтвортой байдлыг хангахын тулд гүйцэтгэсэн ажил нь бодлогын баримт бичиг боловсруулагдсан сайн тал байна. Мөн төслийн хүрээнд төчнөөн хүмүүсийг сургасан гэдэг нь бидний эцсийн үр дүн биш бөгөөд хамгийн сүүлийн том үр дүнгээ байнга бодож байх хэрэгтэй. Мөн төслийн гол 3 үр дүнг байнга санаж байх нь чухал юм. Та бүхэн өнөөдрийн сургалтаар юу сурсан бэ?

**Оролцогчид:** - Бид группээр ажиллаж бусдаас суралцлаа.

- Группээр ажиллаж байгаа нь бусдыгаа юу хийж байгааг мэдэж байна.
- Өнөөдрийн сургалтаар маш их зүйл сонсож, суралцаж байна. Үр дагавар 1, 2, 3 гэсэн үр дүнгээ гаргаж ирсэн нь үр дагаврын эцсийн үр дүнг дөхүүлж чадсан санагдаж байна.
- Та бүхэн тавьсан зорилтдоо одоогийн байдлаар хүрсэн байна. Мөн Иргэдийн оролцоог сайжруулсанаар иргэд, ИНБ, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж байна. Та бүхэнтэй хамтран ажиллах болно.

Кристина Акийно семинарт оролцогчдыг энэхүү сургалтаас олж авсан мэдлэг болон, маргааш юу хүлээж байгаа талаар [www.PollEv.com/ka227](http://www.PollEv.com/ka227) гэсэн хаяг руу нэвтрэн орж, санал асуулгад оролцуулж үр дүнг бүгдэд нээлттэй танилцуулав.

# “МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ”

## төслийн жилийн үр дүнгийн семинар

2017 оны 9 дүгээр сарын 22

Улаанбаатар зочид буудал

“Номын хүрээ” танхим

08.30-09.00 Өмнөх өдрийн семинарын дүгнэлт

**Кристина Акийно:** Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Оролцогчид санал асуулгын [www.PollEv.com/ab697](http://www.PollEv.com/ab697) хаяг руу орж судалгаагаа бөглөнө үү.

1. Энэ өглөө надад ямар мэдрэмж төрж байна вэ?
  - Нойрмог – 15
  - Будлиантай - 2
2. Өчигдөр орой, би ..... талаар бодлоо.
  - Төслийн үр дагаврыг хэмжих тухай
  - Хэд хэдэн газрын хийсэн ажлын талаар хяналт-шинжилгээний лекцийн талаар дахин дахин бодсон
  - Дараагийн төсөл
  - Шалгуур үзүүлэлт зөв тодорхойлох
  - Төслөө хэрхэн амжилттай хэргэжүүлэх
  - Хөтөлбөрөө үр дүнтэй хэнрэгжүүлэх талаах
  - Маргаашийн үйл ажиллагааны талаар
  - Гэр бүл
  - Төсөл үргэлжлээсэй гэж
  - Төслийн үр дагаврыг хэмжих тухай
3. Өчигдрийн хуралдаанаас ойлгомжгүй зүйл байгаа эсэх
  - Тийм 28%
  - Үгүй 72%
4. Өчигдрийн цуглаан дээр юу нь ойлгомжгүй байсан бэ?
  - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулинд заасан хөндлөнгийн хяналт шингжилгээ үнэлгээг хэрхэн хийх вэ? 89-р тогтоол нэмэлт өөрчлөлт оруулах уу?
    - Энэ сэдэв нь маш том сэдэв, гэхдээ бид 1 долоо хоногийн дотор базаж ярих нь хангалттай зүйл биш. Өчигдөр бид ерөнхий ойлголтыг өгсөн байгаа. Энэ талаарх журам гарвал илүү хангалттай зүйл болох байх. Мөн өнөөдөр яамныхан ирнэ, тэр үед бид багаар ажиллах бөгөөд тэднээс асуух зүйл байвал бэлдэж байгаад асуугаарай.
  - ТББ-ууд тодорхой хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байна. Бид улс төр, төрийн байгууллагуудад хэрхэн нөлөөлөх вэ? аливаа үйл ажиллагааг хэрхэн бодитой болгох вэ?
    - Нөлөөллийн асуудлын талаар бид өнөөдөр ярилцана. Тийм болохоор энэ асуудлыг түр хойш нь тавья.
  - Санал асуулгад бүгд оролцоогүй тал байна. Бид өнөөдөр ярьж байгаа зүйлээ ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Бид та бүхний ажлыг хийгээд Монгол улсад хэрэгтэй зүйл гээд хөдөлж байхад энд бодлогын асуудал хариуцсан хүмүүс огт ирэхгүй байна. Бид бүгд л хамтран ажиллах хэрэгтэй байна.

- Бид яамны удирдлага, мэргэжилтнүүдийг энэ 2 өдрийн семинарт урьсан байгаа. Тэд өнөөдөр ирнэ. Өчигдөр бид дотоод асуудлаа нилээн ярилцсан.
- Өмнөх өдрийн хичээл, ажил нилээн товчхон болсон. Санал бодол, туршлагаа хуваалцах хэрэгтэй байна.
  - Өнөөдөр бидэнд тийм боломж гарна.

**Кристина Акийно:** Бид өнөөдөр нээлттэй өгөгдлийг засаглалын асуудалд хэрхэн ашиглах талаар ярилцана. Бид онлайнаар холбогдож хичээл орох юм.

- Та өдөр тутмын ажилдаа нээлттэй өгөгдлийг ашигладаг уу?
  - Тийм
- Эмх цэгцэд оруулсан, оруулаагүй өгөгдлийн ялгаа харагддаг уу?
  - Цаг хугацааг хэмнэдэг. Жишээ нь судалгааны суурь үзүүлэлтүүд эмх цэгцтэй байх нь дараа дараагийн ажилд дөхөм болдог.
  - Цэгцлээгүй өгөгдөл ямар байх вэ? гэхээр жишээ нь ярилцлага хийсэн өгөгдөл байлаа гэхэд зөвхөн 1 хүний л хариултыг харах боломжтой байдаг.

## **МОДУЛЬ 2. ӨГӨГДЛИЙГ НОТЛОХ БАРИМТ БОЛГОН АШИГЛАХ НЬ**

### ***Хэсэг 2.1. Нээлттэй өгөгдөл /09.15-10.45/***

АНУ-ын Вашингтон ДС-ээс өгөгдлийн талаарх мэргэжилтэн Мэрэйтэй онлайнаар холбогдон тэрээр 20 минутын хичээл оров. Түүнээс оролцогчид асуулт асууж хариулт авсан юм.

*Иргэдийн онооны карт (ИОК)-ыг ашиглахад тулгамдаж байсан гол асуудал юу байсан бэ?*

Эрүүл мэндийн салбарт бид ИОК-ыг ашиглан судалгаа хийсэн. Энэ үед дараах аргуудыг ашигласан. Үүнд:

- Сүрьеэ өвчин улсын хэмжээнд 1-рт орж байсан. Мөн энэхүү өвчний талаар судлахдаа баримт бичиг, стандартуудыг ашигласан. Мөн иргэдэд энэ талаар маш сайн мэдээлэл хүргэж өгсөн.
- ИОК-ыг ашиглан судалгаа авахдаа асуултаа маш сайн боловсруулж, хангалттай мэдээллийг авсан байна.

*Өгөгдлийг интернетээс шууд хайж авдаг уу? Өгөгдлийг хэрхэн mapping хийх вэ?*

- Газрын зураг болгохын тулд google map руу орж байгаад шууд өөрийн дата-г газрын зураг болгох боломжтой.
- Мөн тарбох гэсэн багаж байдаг. Ер нь нилээн өгөгдлөөр газрын зураг бий болгодог. Мөн CART гэсэн арга аргачлалуудыг ашиглаж болдог.

*Өгөгдлийг харуулах платформыг хэрхэн бий болгох вэ?*

- Web платформ бий болгож бусдад харуулахыг хүсвэл MockFlow-г ашиглан өөрийн платформыг үүсгэж болно.

Өгөгдлийг хэрхэн боловсруулалт хийх талаар хичээл орсон Мэрэй-д маш их баярлалаа.

### **10.13-10.50 Цайны завсарлага**

Аймгуудад хэрэгжиж байгаа дэд төслүүдийн танилцуулга хийв.

**Хэнтий аймгийн дэд төслийн танилцуулга: “Эмзэг бүлгийн эмнэлэгийн тусламж үйлчилгээг сайжруулах нь”**

*Үр дүн 1:*

1. Хэрлэн сумын 1, 2, 8 дугаар багийн зорилтот бүлгийн 2900 хүнээс 85 хувьд нь эрүүл мэндийн байгууллагаас олгох сургалт, мэдээллийн ажиллагаанд хамруулсан, эрүүл мэндийн боловсрол олгосон.
2. Хэрлэн сумын 1, 2, 8 дугаар багийн зорилтот бүлгийн давхардсан тоогоор 3445 хүний урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.
3. Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй 260 хүний 148-ыг нь эрүүл мэндийн даатгалд хамруулсан.
4. Зорилтот бүлгийн иргэдээс ИОК-ын аргаар авсан үнэлгээнд 20.3 хувийн үзүүлэлтээр сайжирсан үнэлгээ өгсөн. Анх 35.6 хувь байснаа дараа 55.9\* хувь болж өссөн.
5.  $23+20=43$  иргэд төрийн үйлчилгээг үнэлэх ИОК-ын аргачлалд суралцаж чадавхжсан.

*Үр дүн 2: Төрийн үйлчилгээг сайжруулах.*

- Төслийг үр дүнтэй зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан.
- БОЭТ-ийн цаг товлох үйлчилгээний журмыг шинэчлэн боловсруулж баталгаажуулан мөрдөн ажиллаж байна.
- Эмнэлэгийн ажилтан нарын үйлчилгээний стандартыг шинээр боловсруулж баталгаажуулсан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгээр хүүхдийн шүдний эмчилгээний суурь машин 2 ширхэгийг худалдан авч, хүүхдийн шүдний кабинет байгуулсан.
- Нийгмийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг ОНХС-аас гаргуулж уг кабинетийг байгуулсан.
- Ахмадын кабинет байгуулсан.
- Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох өдөртэй болсон.
- Төрийн, ИНБ хамтарч хэрэглэгчийн хөндлөнгийн үнэлгээг жилд 1 удаа хийхээр болсон.
- Цаг бүртгэлийн гарын хээний 3 машинтай болсон.

*Сайжруулах байсан зүйл:*

- ✓ Үлдсэн 1112 хүнийг эрүүл мэндийн даатгалд хамруулах,
- ✓ Өвчлөлтэй гарсан 83 хувьтай хүмүүсийг эмчилж эрүүлжүүлэх,
- ✓ Хөндлөнгийн үнэлгээний зарчмыг орон нутгийн төсөвт суулгахажлыг зохион байгуулах.

**Сэлэнгэ аймгийн дэд төслийн танилцуулга: “Сүрьеэ өвчний тархалтын байдал”**

Иргэд, ИНБ төрийн үйлчилгээнд үнэлэлт өгч үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн:

- Чадавхижсан иргэд, ИНБ,
- “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөр,
- Хүний нөөц, тоног төхөөрөмж, сүрьеэгийн эмнэлэгтэй болсон,

- Нийт аймгийн иргэдэд ИОК-аар нийгмийн эгэх хариуцлагын ойлголтыг хүргэх.

**Говь-Алтай аймгийн дэд төслийн танилцуулга:** “Сайн засаглал, оролцоот сургууль”

*Төслийн хүрээнд бид юу хийсэн бэ?*

- Сайн сургууль, тулгамдсан асуудлаа нотолгоо, баримттай тодорхойлж, олон талын зүгээс юу хийхээ төлөвлөсөн.
- Сайн сургуулийг дэмжих багийн бүрэлдэхүүнийг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулсан.
- Олон талын төлөөлөл нэгдэж, сургуулиа сайжруулж болно гэдгээ, түүнд оролцохоо ойлгосон.

*Төслийн хүрээнд 3 үр дүнг тодорхойлсон.*

4. Иргэд, ИНБ-ууд, төрийн байгуулагууд хамтран ажиллаж чадсан.
5. Сайн сургуулийн дэмжих аргачлалыг бий болгосон.
6. 2 дахь үр дүнг хийснээр иргэдэд таниулах, түүнийг дэмжих аргачлалыг олж авсан.

Хамтран ажиллахад бие биенээ маш сайн ойлголцож байсан. Зарим нэг сул талууд гарч байлаа. Үүнд:

- Дэд төсөл 4 дүгээр сард бус 1 дүгээр сард эхэлсэн бол илүү үр дүнтэй, зуны амралт, сонгуулийн үйл ажиллагаанд шахагдахгүй байх байсан.
- Сургалт 9-р сард хийгдсэн бол илүү олон хүмүүсийг хамруулах боломжтой байсан.
- Иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдал гэж 15 хоног хязгаарлагдсан.

**Говьсүмбэр аймгийн дэд төслийн танилцуулга:** “Эрүүл мэндийн салбар дахь НЭХ-ын төсөл”

1. ИОК-аар суурь судалгаа хийсэн.
  - Одоогийн байгаа түвшингээ мэдэх
  - Эрүүл мэндийн байгууллага, иргэдийн хандлага өөрчлөгдсөн.
    - o Иргэдийн идэвх оролцоо сул байсан
2. Иргэдийг мэдээллээр хангаж, чадавхжуулах.
  - Орон нутагтаа тохирсон нэвтрүүлэг, шторк бэлтгэж хүргэсэн.
    - o Хөндлөнгийн болон гэр хорооллын айл өрхөд хүрэх боломж хязгаарлагдмал.
3. Амбулаторийн үйлчилгээний хүлээлгийн цаг бууруулах (цахим эрүүл мэндийн үйлчилгээ).
  - Цахим бүртгэл нэвтрүүлж, хүлээлгийн цаг буурсан.
  - Эмч, эмнэлэгийн мэргэжилтнүүдийн цаг ашиглалт сайжирсан.
    - o Иргэд өөрчлөлтийг хүлээж авахдаа муу байсан.
4. Шатлал хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх тогтолцоог сайжруулах.
  - Эрүүл мэндийн яамтай холбоо сайтай ажилласан.
    - o Журам гаргах болсонтой холбоотой хэрэгжүүлэх шаардлагагүй болсон.

### **МОДУЛЬ 3. БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ**

**Хэсэг 3.1. Бодлогын нөлөөлөл /11.15-12.30/**

Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуулийн захирал доктор, дэд профессор Я.Бямбасүрэнгийн “Зүүн өмнөд азийн улс орнуудын нийгмийн эгэх хариуцлага: Туршлага, сургамж, сорилт” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлийг 10 минутын видео бичлэг үзүүлэв. Энэхүү илтгэлд НЭХ-ын талаарх үндсэн ойлголт, түүх, бодлогын асуудлын талаар дурдагдсан юм.

**Пүрэвтогтох:** Модуль 3 “Бодлогын өөрчлөлтөд нөлөөлөх нь” хэсэгт 3 илтгэл сонсоно. Үүнд:

1. “Бодлогын нөлөөллийн үйл ажиллагаа” доктор, өмгөөлөгч Д.Сүнжид /11.30-11.54/
2. “Бодлогын нөлөөлөл: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо” ХЭҮТ-ийн тэргүүн Д.Энхжаргал /11.55-12.23/
3. “Бодлогын нөлөөлөл орон нутагт” Ховд аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн Нарандорж /12.23-12.35/

### АСУУЛТ, ХАРИУЛТ:

**Пүрэвтогтох:** Бид бодлогын нөлөөллийн ажлыг хийхдээ хамтын ажиллагааг чухалчлах хэрэгтэй юм. Орон нутгийнхан энэ асуудалд маш сайн хамтран ажиллах хэрэгтэй. Бид их олон бодлогын бичиг баримт хууль тогтоомжид нилээн их ажил хийсэн байгаа боловч цогцоор нь харж байгаагүй. Ингэж харсанаар бид зөвхөн бодлогын бичиг баримт гаргаад зогсохгүй цогц зүйлийг хийх нь зүйтэй юм байна гэж харагдаж байна. Бидний хувьд цаашид хийх ажил маш их байна. Одоо мөрдөгдөж байгаа шинээр гарсан 4 хууль байна. Орон нутгийнхан ИТХ-тайгаа хамтран ажиллаж байж хуулинд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

**Оролцогч:** Хамтран ажиллаж байгаа багийн үйл ажиллагаа орон нутгийн түвшинд учир дутагдалтай байгаа тул цаашид үүнийг сайжруулах ямар боломж байна вэ?

**Энхжаргал:** Хууль батлагдахаас өмнөх дүр зургийн талаар асуулт асуулаа. Одоо хууль батлагдсан байгаа. Хамтарсан багийн үүрэг, төсвийн талаар шинэчлэгдсэн хуулинд тодорхой зааж өгсөн байгаа.

**Оролцогч:** Хамгаалах байрыг орон нутгийн түвшинд хэрхэн байрлуулах вэ? Үүнийг хуулиар хэрхэн зохицуулах вэ?

**Энхжаргал:** Аймаг бүр маш олон янзын хамгаалах байрыг бий болгож байна. Иймд нэгдсэн стандарттай байх хэрэгтэй бөгөөд НХХЯ-аас төсөв, ажиллах журам зэрэг бүхий л зүйлийг нь тусгасан журам гаргаж байгаа.

### 12.30-13.30 Өдрийн хоол

Аймгуудад хэрэгжиж байгаа дэд төслүүдийн танилцуулга хийв.

**Увс аймгийн дэд төслийн танилцуулга:** Увс аймгийн эм, эмнэлэгийн хэрэгслийн худалдан авалтанд НЭХ-ыг бэхжүүлэх нь “Хамтын Х.Ү.Ч”, орон нутгийн зөвлөх В.Төөрүүл /13.51-13.56/

*Оролцогч байгууллагууд:*

- Аймгийн ИТХ-ын Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороо,
- Аймгийн ЗДТГ – Нийгмийн байгуулалтын хэлтэс
- Эрүүл мэндийн газар

- Нэгдсэн эмнэлэг – хэрэгжүүлэгч
- ТББ – 11
- Хэвлэл мэдээлэл (сонин, телевиз)
- Худалдан авах алба

*Хэрэгжүүлсэн аргачлал:*

- ✓ ОНОКарт
- ✓ ИОНО хяналт
- ✓ Өөрийгөө үнэлэх

*Хийсэн ажил*

1. ОНОК-ын асуумжаар үйлчлүүлэгч, түүний гэр бүл 250, эмч, эмнэлэгийн ажилтан 250 хүний хамруулсан судалгаа хийсэн.
2. ЭЭХ тендер шалгаруулалт, шалгарсан ЭЭХ нийлүүлэгч компанитай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих (марль, эм буцаасан 10 хүн, 14 компани).
3. ЭМГ үнэлгээний хороог шинэчилсэн.
4. ТЖББ-д нэмэлт оруулж боловсруулсан.
5. Нэгдсэн эмнэлэгт хэрэглэж байгаа 129, ЭЭХ-ийн чанар, байдалд хяналт тавих, судалгаа хяналтын багт 15 эмч, мэргэжилтэн ажиллаж байна.
6. Сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, арга зүйн зөвлөмжийг тогтомог өгдөг болсон.

*Үр дүн – Эрүүл мэндийн газар:*

- Эрүүл мэндийн салбарт хэрэгцээтэй ЭЭХ-ийн нэгдсэн тендер шалгаруулалт зарласан. Хэмнэлт 108.9 сая төгрөг болов.
- ТЖББ-ын тусгай нөхцөлд эмийн чанарт лабораторийн шинжилгээ хийлгэх зардлыг тусгасан.

*Үр дүн – Нэгдсэн эмнэлэг:*

- Эм, эмнэлэгийн хэрэгслийн хэрэгцээ тодорхойлсон (3 жил),
- Эмийн тасалдал 12.9 хувиар буурсан,
- Лабораторийн урвалж, оношлуур хангамж 2 дахин нэмэгдсэн.

*Үр дүн – ТББ:*

- Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих аргачлал бий болгосон.
- Үр дүнгээ мэдээллэсэн.
- Хамтын ажиллагаа сайжирсан.

*Тогтвортой байдлыг хангах эрхзүйн үндэслэл:*

- Миний Увс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “НЭХ-ыг бэхжүүлэх төсөл”-ийг дэмжих,
- Эрүүл мэндийн салбарын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт элемент бүрээр тусгасан,
- Холбогдох ажилтан, мэргэжилтэн чадавхжсан.

**Дорнод аймгийн дэд төслийн танилцуулга:** “Эмзэг бүлгийн иргэдийн эмнэлэгийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх” хийв.



**Кристина Акийно:** Дэд төслийн танилцуулга хийсэн багуудад баярлалаа, эдгээр танилцуулгууд бүгд ач холбогдолтой, маш сайн ажиллаа.

#### **ДАСГАЛ АЖИЛ: САФАРИ ТҮҮХ /13.15-15.15/**

Бодлогын чанартай асуудал яригдах бөгөөд нийтлэг хүндрэл бэрхшээл юу байна, аймгийн ЗДТГ-ын түвшинд эсвэл боловсрол, эрүүл мэндийн салбарт гарч байгаа нийтлэг хүндрэлийн талаар ярилцах ёстой юм.

4 салбар байна.

- Боловсрол
- НЭХ-ын үйл явц болоод иргэдийн оролцоо
- Эрүүл мэнд
- Нутгийн удирдлага

Өөр нийтлэг салбар, сэдвүүд байж болно. Ямар өөр нэн тэргүүний, чухал сэдвүүд байж болох вэ? энэ 4 сэдэв болж байна гэж үзлээ. Энэ 4 сэдвээс сонгож ажиллацгаая. Бүлэг дундаа, өөр хоорондоо ярилцан ажиллаж болно. 4 сэдвийг баг бүрт хувааж өгөв.

Оролцогчид холилдон өөр өөрсдийн сонирхсон бүлэгтээ очиж нэгдэв. Баг шинээр бүрэлдэв. Кристина Акийно уг дасгал ажлын удирдамжаар хангав.

Бид өглөө бодлого боловсруулах, бодлогын нөлөөллийн талаар сонссон.

1. Бодлого боловсруулахад Ямар нийтлэг хүндрэл, бэрхшээл байна вэ? түүнийг хэрэгжүүлэхэд ямар нийтлэг асуудал тулгарч байна вэ? гэдэг талаас нь харилцан ярилцана. Нийтлэг бэрхшээл, түүнийг даван туулах мэдлэг арга хэрэгсэл, үр дүн болон нотолгооны талаар ярих юм.
2. Хэлэлцсэний үр дүнд Засгийн газар болон бодлого боловсруулагчид зориулан саналаа илэрхийлж бичнэ. Тэрхүү саналаа баталгаажуулах нотолгоо байх ёстой.

#### **15.15-15.30 Цайны завсарлага**

**“НЭХ-ын төсөл: Бид хаана явна вэ?” Дэлхийн банк Марсела** танилцуулга хийв. /15.20-15.38/

**Кристина Акийно:** Баярлалаа Маселла. Одоо сүүлийн хэсэг рүүгээ орёе. Бид их үр бүтээлтэй 2 хоногийг өнгөрөөж байна. Одоо танилцуулгаа эхэлье.

#### **БАГИЙН ИЛТГЭЛ, ТАНИЛЦУУЛГА /15.40-16.33/**

- **Боловсролын салбарын баг**

Манай багийнхан хоорондоо ярилцаад дараах саналуудыг гаргаж байна. Бэрхшээл:

1. Санхүү
2. Хүний нөөц
3. Хамтын ажиллагаа
4. Сэтгэл зүйн орчин
5. Үнэлгээ

Эдгээр бэрхшээлийг даван туулах арга зам:

- a/. Төр, ИНБ, олон нийт, ИНБ, иргэдийн санаачилга, чадавх

б/. Зарим эрхийг шилжүүлэх

в/. ИНБ-уудыг дэмжих

г/. Мэргэжлийн удирдлага (улс төрөөс ангид байлгах)

#### САНАЛ:

- ✓ НЭХ-ын дэд төслүүдийг бүх орон нутагт хэрэгжүүлэх,
- ✓ Төслийн санхүүжилтийг Орон нутагийн хөгжүүлэх сангаас гаргуулах асуудлыг шийдүүлэх,
- ✓ Иргэд, төр, ИНБ-ын сэтгэл зүйн орчинг өөрчлөх, хөгжүүлэх,
- ✓ Хурдан явъя гэвэл ганцаараа яв, хол явъя гэвэл бүгдээрээ яв.
- ✓ Сургууль бүр өөрийн онцлогт тулгуурласан загвар хэрэгжүүлэх
- ✓ Сургууль хөгжүүлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, шийдвэрлэх шаардлагатай.
- ✓ Сумынхаа хэмжээнд тухайн сумыг хөгжүүлэх арга хэмжээ авах боломжийг бий болгох хэрэгтэй.

#### **Оролцогчдоос санал:**

- ✓ Төрөл бүрийн санал байна. Илүү хэрэгжих боломжтойгоос нь эхэлбэл:
- ✓ ИНБ, иргэдийн саналыг дэмжих гэсэн нь боломжтой юм.
- ✓ Яамдаас иргэдийн саналыг дэмжих боломжтой гэж бодож байна.
- ✓ Сургуулийн захирлыг сонгох, улс төрөөс салангид байлгах гэсэн нь бүх л улс оронд ижил байдаг. Гэхдээ улс төрийн нөхцөл байдлаас салгах боломжгүй болов уу.
- ✓ Мөн ОНХС-аас хөрөнгө гаргах боломжтой байх гэж бодож байна. Үүнд та бүхэн нөлөөллийн ажил хийх нь чухал юм.
- ✓ Улс төрийн томилогоог өөрчлөх гэдэгт аливаа 1 зүйлд альтернатив механизм хийх хэрэгтэй ба өөр ямар сонгууль байж болох талаар та бүхний санал чухал байх. ОНХС-аас санхүүжилтийг авахдаа хамгийн гол үндэслэлийг гаргах нь зүйтэй.

**Оролцогч:** Та бүхний санал нилээд үнэ цэнэтэй бөгөөд тухайн салбарт тулгамдаж байгаа асуудлыг хөндөн гаргаж ирсэн байна. Ялангуяа сумдын сургуулийг хөгжүүлэхдээ сумын ИНХ-тай хамтран ажиллах хэрэгтэй гэсэн санал нь илүү сайн санал байлаа. Мөн эдгээр гарсан саналуудыг бид яам, Засгийн газарт хүргүүлэх нь зүйтэй гэж бодож байна.

#### **- *НЭХ-ын үйл явц болоод иргэдийн оролцоо***

Манай багийнхан хоорондоо ярилцаад дараах саналуудыг гаргаж байна. Бэрхшээл:

1. Засгийн газрын боловсруулж буй (ХЗДХЯ) бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрт төрийн үйлчилгээ, албаны төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, түүний хяналт тавих тухай мэдлэг, ур чадвар олгох заалт нэмэх гэсэн асуудлуудыг тусгаж байгаа. Энэ асуудал нь иргэдэд мэдээлэл дутмаг байна гэж үзсэн.
2. Удирдах ажилтан гэрээний биелэлтийг тооцохдоо шалгуурыг үр дүнгийн гэрээнд тусгасан эсэх
3. Иргэд сэтгэл ханамжийн үнэлгээг хийх мэдлэггүй тул үнэлгээ хийх боломж муу байна.

Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд:

а/. Иргэн, олон нийт, төсвийн ерөнхийлөн зохицуулагч, нягтлан бодогч зэрэг төрийн алба хаагч, ТББ, ИНБ-ын хамтарсан бүрэлдэхүүнтэйгээр хамтарсан олон талт механизм байгуулахыг ИТХ-д таниулж, жил бүр төсвийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилт, хяналт, үнэлгээг хамтаар хийж турших,

#### САНАЛ:

- ✓ Улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо сэтгэл ханамжийн үнэлгээг тулгуурлах ба иргэдээс авах оноог нэмэх,
- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцохдоо Засаг дарга тусгайлан шалгах, үнэлэх, иргэдэд үнэлгээг хийх аргачлал хийх,
- ✓ Дараа жил нь бууралт гарахгүй байх,
- ✓ Иргэд өөрсдөө хянах,
- ✓ Ямар нэгэн асуудал давтагдвал эрх цуцлах санал гаргах гэх мэт.

#### *Оролцогчдоос санал:*

- ✓ Эрүүл мэндийн салбарт сэтгэл ханамжийн судалгааг авах заавар дүрэм журам байдаг, түүний дагуу судалгааг авдаг. Мөн арга аргачлалыг нарийвчилж гаргаад боловсруулах нь илүү чухал юм болов уу.
- ✓ Үйлчлүүлэгч, үйлчлэгчийн сэтгэл ханамжийг гаргахдаа тэдний үнэлгээний боловсролын тал дээр анхаарах, мэдлэг өгөх хэрэгтэй санагдлаа.
- ✓ Хөвсгөл аймагт мөн ийм туршлага байгааг бусад нь мөн туршиж үзэх боломжтой юм байна гэж бодож байна.

#### *- Эрүүл мэндийн салбар*

Эмнэлэг болон сургуулийн гүйцэтгэлийг олон нийтэд мэдээллэх нь гэсэн судалгаа мөн хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь олон улсын стандартаар харьцуулсан байдлаар үр дүнг гаргаж иргэд, олон нийтээр дүгнүүлдэг туршлага байдаг.

#### Бэрхшээл:

1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, тогтолцоо, санхүүжилт, хүний нөөцийн чадавхи нийгмийн шаардлагыг хангахгүй байна.
2. Хууль эрх зүйн орчинд асуудал байна
3. Салбар хоорондын уялдаа хүндрэлтэй байна
4. Иргэдийн оролцоо хангалтгүй
5. Төсөв, хөрөнгө оруулалт хангалтгүй
6. Төсөв, стандарт, иргэдийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй.
7. Улс төрийн оролцоо ихтэй.
8. Түр оршин суугчдын асуудал хүндрэлтэй, бүртгэлгүй.

Гэх мэтчилэн дээрээсээ иргэнийг хүртэл бэрхшээл, хүндрэл байна.

#### Эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд:

- а/. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль, стандарт хангагдсан, хуулиа хэрэгжүүлэх, шинэ хуулиуд батлах,
- б/. Сайн жишээг нэвтрүүлэх, төвлөрсөн худалдан авалт, ОУВС, ИОК-аар үнэлүүлэх,

в/. Сайдын тушаал шийдвэр батлагдсан гэхчилэн бодлогын баримт бичгүүдийг боловсрулан хэрэгжүүлэх боломжтой болсон байна.

г/. Эмийн худалдан авалт,

д/. НЭХ-ын асуудлыг хуульчилах

Нотолгоо:

- ✓ Говьсүмбэр - сэтгэл ханамж өндөр,
- ✓ Увс – М2000,
- ✓ Сэлэнгэ - сэтгэл ханамж өндөр,
- ✓ Хөвсгөл - сэтгэл ханамж өндөр,
- ✓ Бодлогод нөлөөлөх хэмжээний үйл ажиллагаа явуулах нь чухал байна.

САНАЛ:

- ✓ Зардал гэдэг нь тодорхой байх хэрэгтэй байна. Бид дороосоо зөв, тодорхой гаргаж байж төсвөө батлуулах боломжтой юм.
  - ✓ Хөндлөнгийн хяналтыг ИНБ-аар хянуулах боломж тааруу, үүнийг зохицуулах эрх зүйн акт байдаггүй. Иймд үүнийг дүрэм журмаар баталгаажуулах шаардлагатай. Хөндлөнгийн үнэлгээг өөр хүмүүсээр хийлгэх нь чухал.
  - ✓ Үр дүн бий болсон сайн саналыг хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү төсөл цаашид хөгжиж, үргэлжилж явахад 10 аймаг өөр хоорондоо туршлагаа хуваалцах хээгтэй байна.
  - ✓ Иргэдийн оролцоог сайжруулах нэн шаардлагатай байна. Төрийн үйлчилгээг сайжруулахын тулд иргэдийн санал хүсэлтийг тусган авснаар үйлчилгээг сайжруулах боломжтой гэж үзэж байна.
  - ✓ Сайдын шийдвэрт иргэд нөлөөлж болдог гэдгийг бид тод томруунаар жишээ болгон харуулах, ажиллах хэрэгтэй байна гэж бодож байна.
  - ✓ Бүх аймгуудын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлыг голчлон гаргаж өгөх хэрэгтэй гэж ойлгосон бөгөөд аймаг, сумдад түр оршин суугчдын асуудал мөн чухал асуудал юм. Иймд иргэн бүр өөрийн гэсэн бүртгэлтэй, данстай байх нь шилжин суурьшихад элдэв хүндрэл үүсэхгүй байна гэдгийг мөн санал болгож байна.
- *Нутгийн удирдлага*

Бэрхшээл:

1. Төрийн болон ТББ-уудын үл ойлголцол, уялдаа холбоо тааруу,
2. Ажлын давхцал
3. Удирдлагын зохион байгуулалт
4. Статус. Өрхийн эрүүл мэндийн төвийн талаарх хууль, тогтоомж, бодлого хангалтгүй. Эрүүл мэндийн сангаас оношийн кодоор санхүүждэг. ....
5. Хамтран ажиллах
6. Хувь хүний хандлага
7. Ойлголцлын зөрүү

Аргачлал:

а/. ИОК – төр өөрийгөө үнэлсэн,

б/. Хөндлөнгийн хяналт – иргэд, ТББ-ын оролцоотой,

в/. Ойлголцлын санамж бичиг – талууд хамтын ажиллагаагаа тодорхойлсон

САНАЛ:

- ✓ Анхан шат – Хамтран ажиллах ойлголцол,
- ✓ Орон нутаг, засаг захиргаа – Хамтран ажиллах ойлголцол,
- ✓ Бодлогын түвшин – анхан шатнаас нь иргэдийн хүсэл зориг “Амьд” байх.

Гол үр дүн:

- Анхан шатанд:
  - Асуудлаа хамтр тодорхойлсон,
  - Дотоод нөөц бололцоогоо ашиглах (үйлчилгээний стандарт бий болгох, цахим дугаарлалт гэх мэт),
  - Баг болж чадсан – анхан шатны төр, ТББ, иргэд, баг, Засаг дарга, нийгмийн ажилтан нарын хоорондын “Ойлголцол”,
- Орон нутгийн засаг захиргаа:
  - ИТХ-ын үйл ажиллагааг идэвхжүүлсэн (Ойлголцлын санамж бичиг, шийдвэрүүд),
  - Аймгийн Засаг даргын Тамгын газарт – НБХ (эрүүл мэнд, боловсрол)-ийн хэрэгжилтийн хурд дээшилсэн,
  - Уялдаа холбоо сайжирсан,
  - Ойлголцол, тогтвортой байдал тодорхой үр дүнд хүрсэн.
- Бодлого:
  - Хууль тогтоомжид санал оруулах,

***Оролцогчдоос санал:***

- ✓ Баримтад суурилсан гэдэг тал дээр ИНБ нь төрийн байгууллагадаа итгэх, ойлголцол бий болгох,
- ✓ ИТХ-аар санал гаргаад, албан ёсны болгож хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм. Мөн нийгмийн бодлогын хувьд Сүнжид багшийн хэлсэнчлэн саналаа авч төслийнхөө жишээг хавсарган хүргүүлэх боломжтой юм.

**Кристина Акийно:** 4 багтаа бүгдэд нь илтгэл тавьсанд баярлалаа. Хүн бүр маш их туршлага хуримтлуулсан, маш их мэдээлэл цуглуулсан, Засгийн газарт хэрхэн нөлөөлж болох талаар тодорхой мэдлэгтэй боллоо. Одоо харин бид өөр хоорондоо туршлагаа хэрхэн солилцох вэ гэдгээ сайтар бодолцох хэрэгтэй болох юм байна. Семинарын дүгнэлт, хаалтыг Д.Амарбаясгалан дүгнэж хаана.

***СЕМИНАРЫН ҮНЭЛГЭЭ БА ХААЛТ /16.35-17.00/***

**Д.Амарбаясгалан:** Сургалт дуусах дөхөж байна. Та бүхэн уламжлалт семинарын үнэлгээг хийж, бөглөж өгнө үү. Үнэлгээний хуудас бөглөж өгсөн та бүхэнд баярлалаа.

Одоо <https://pollev.com/ab697> линк руу орж саналаа өгнө үү.

1. Юу мэдэрч байна?
  - Ядарч байна
  - Сайхан байна
  - Гайхалтай

- Халуун, бөгчим байна
  - Сэтгэл хангалуун
2. Өнөөдөр би шинэ зүйл сурсан
    - Тийм 100%
    - үгүй
  3. Өнөөдрийн хамгийн их таалагдсан зүйл юу байсан бэ?
    - Хоол
    - Онлайн сургалт
    - Дата
    - Энхжаргалын сургалт
    - Нээлттэй өгөгдөл
    - Цаашид хэрэгжүүлэх санаанууд
    - Оролцоо
    - Гимнастик
  4. Сонирхолтой болон шинэ содон санагдсан зүйл юу байсан бэ?
    - Онлайн хичээл
    - Pollev
    - Өгөгдлийн аргууд
    - PDS-с Word рүү хөрвүүлэх
  5. Өнөөдрийн хамгийн сэтгэлд нийцээгүй зүйл юу байсан бэ?
    - Байхгүй                                 - Гайгүй
    - Шөл   - Баасандах боломж олгох
    - Цайны цаг   - Хэт хурдан ярих
  6. Энэ цуглааны дараа би илүү их хичээн ажиллах болно
    - Тийм 19
    - Үгүй
  7. Энэ семинарын дараа миний хийх зүйл бол....
    - Нөлөөллийг үргэлжлүүлэх
    - Түгээх
    - Дараагийн ажилдаа НЭХ-ыг ашиглах
    - Бусдаасаа суралцах
    - Түгээх
    - Сурсан зүйлээ туршиж үзнэ.
    - Тогтвортой байдлыг хангах
    - Тайландаа энэ сургалтаа шигтгэж бичнэ
    - Төслөө сайжруулна.
    - Тайлан бичнэ.
    - Дараагийн ажлаа хурдална.
    - Багийн гишүүддээ мэдээллээ өгнө.

Бүгдэд нь маш их баярлалаа.

**Кристина Акийно:** бид цаашид хэд хэдэн зүйл хийнэ. 2 түвшинд ажил хийнэ. Эхнийх нь дэд түвшинд, нөгөө нь үндэсний түвшинд ажлуудыг хийнэ.

Дэд төслүүд:

- Улаанбаатар хотын төслүүдийг ирэх 7 хоногоос хэрэгжүүлж эхэлнэ.

- 10 аймгуудад дахин энэ төслүүд хийгдэх бөгөөд бидний хийж байснаас арай өөрөөр хийгдэх байх. Зарим аймагт бидний төсөл амжилттай, амжилтгүй 2 янз байсан. Зарим аймагт төсөл үргэлжилнэ, зарим нь дууссан байгаа. Заримд нь нэг аймгийн туршлагыг нөгөө аймагт хэрэгжүүлэх гэх зэрэг ажлууд байна.
- Мөн шинэлэг зүйлүүдийг нэвтрүүлэх ажил байна. Дараа дараагийн үе шатандаа шинэчлэлийн асуудлыг чухалчилна.

Бид мэдээллийг 2 сарын дотор хүргүүлнэ.

Үндэсний түвшинд:

- Бодлогын нөлөөллийг ЗГХЭГ, Боловсрол, эрүүл мэндийн яамдуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Удирдлагын академитай хамтран НЭХ-ын сургалт явагдаж байгаа. Энэ богино сургалт сургалтын хөтөлбөрт тусгагдсан байгаа. Шинээр суралцах хүмүүсийг энэхүү сургалтад хамруулахыг МАСАМ зохион байгуулна.
- Олон талт хэлэлцээр, шинжлэх ухаан, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллана. Мөн мэдээлэл түгээх, хангах нийлүүлэлт, худалдан авалтын мэдээллийг вэбсайтад байршуулна.

Дараагийн 6-8 сарын хугацаанд бид ийм төлөвлөгөөтэй ажиллахаар төлөвлөж байна. Дараа нь 1 жилийн дараа уулзахад илүү олон зүйлийг ярилцах боломжтой байх болов уу. Бид энэ удаад сургалтаа арай өөр байдлаар хийхийг оролдлоо. Та бүхэнд маш их баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Нийслэлийн төсөл нь аймгуудад хэрэгжсэнээс арай өөр байдлаар хэрэгжүүлэх гэж байгаа. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд бодлогын баримт бичиг дээр ажиллах юм. Нийслэлийн 3 дүүрэгт 4 байгууллага ажиллахаар сонгогдсон байгаа.

**Пүрэвтогтох:** Одоогийн байдлаар 1 газар л үйл ажиллагааны тайлангаа өгсөн байгаа. Бусад нь хугацаандаа ирүүлнэ гэдэгт найдаж байна.


**Кристина Акийно:** Бүгдэд нь баярлалаа.

**Марселла:** Юуны өмнө маш гайхамшигтай ажлыг 2 өдрийн турш хийсэнд маш их баярлалаа. Та бүхнийг хамтран ажиллаж байгаад үнэхээр их баярлаж байна. Энэ эрч хүчээ төслийнхөө дараа ч гэсэн хадгална гэдэгт итгэж байна. НЭХ-ыг хэрэгжүүлнэ гэдэг нь үнэхээр хүндхэн асуудал боловч бид бага багаар, алхам алхамаар урагшилж байгаа. Бид бие биенээс суралцан хамтран ажиллаж байгаарай, цааш цаашдынхаа ажилд ч мөн энэхүү туршлага мэдлэг дээрээ тулгуурлан ажил үүргээ гүйцэтгэнэ гэдэгт итгэж байна. Ингээд аймаг бүртээ НЭХ-ыг бэхжүүлэх ажил үйлстээ улам бүр чармайн ажиллаарай. Улаанбаатар хотын төсөлд ажиллах хүмүүстээ мөн амжилт хүсье. Мөн Д. Амарбаясгалан, Пүрэвтогтох, Кристина Акийно, орчуулагч, техникийн ажилтан нартаа маш их баярлалаа.

## НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫН ҮР ДҮНГИЙН СЕМИНАРЫН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭ

Нийгмийн эгэх хариуцлагыг Монгол улсад бэхжүүлэх төслийн хүрээнд “Нийгмийн эгэх хариуцлагын үр дүнгийн семинар” 2017 оны 9 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Улаанбаатар зочид буурлын “Номын хүрээ” танхимд боллоо. Энэхүү семинарын үр дүнг үнэлүүлэхээр семинарт оролцож буй орон нутгийн 30 төлөөллөөр семинарын төгсгөлийн үнэлгээний хуудас бөглүүллээ. Уг үнэлгээг нэгтгэж үзвэл:

**Зураг 1. Семинарын зорилго тодорхой, ойлгомжтой байсан эсэх байдал**



Семинарын зорилго тодорхой, ойлгомжтой байсан уу? гэсэн асуулт 1-д 30 хүн хариулсанаас 5 оролцогч буюу 16.7 хувь нь “бараг тийм”, 25 оролцогч буюу 83.3 хувь нь “маргаангүй тийм” гэж хариулжээ. Тэгэхээр бид зорилгоо ойлгомжтой, тодорхой, зөв тодорхойлж чадсан байна.


Харин бид семинарын зорилгодоо хүрч чадсан эсэх талаар асуухад мөн л асуулт 1-тэй адил үр дүн буюу “бараг тийм” гэж 16.7 хувь, “маргаангүй тийм” гэж 83.3 хувь нь хариулсан байна.

Семинарын сэдвүүд тухайн байгууллагатай хамааралтай байсан эсэх талаар асуухад судалгаанд оролцогчдын 90 хувь нь “маргаангүй тийм”, 10 хувь нь “бараг тийм” гэсэн хариулт өгчээ. Бид семинарын сэдвийг тухайн байгууллагад зайлшгүй хэрэгтэй, байх ёстой асуудал хэмээн сонгосон байна.

Семинарын явцад сэдэв тус бүрт хангалттай цаг зарцуулж чадсан эсэх талаар асуулт 4-өөр асуухад судалгаанд оролцсон 30 оролцогчийн 17 буюу 56.7 хувь нь “Бараг тийм” гэж хариулсан байхад 13 хүн буюу 43.3 хувь нь “маргаангүй тийм” гэж хариулжээ. Үүнээс үзэхэд бид сэдвээ сайн, зөв сонгож чадсан хэдий ч зарим нэг сэдвийг арай их эсвэл арай бага хугацаанд тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй байжээ гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.


**Зураг 2. Семинарын сэдэв танай байгууллагад хамааралтай болон сэдвүүдэд зарцуулсан хугацаа хангалтаай байсан эсэх /хувиар/**





Мөн асуулгаар сэдвийн хүрээг хангалттай хамарч чадсан болон сэдвүүд хоорондоо уялдаатай байж чадсан эсэх талаар асуухад сэдвийн хүрээг хамарч чадсан талаар оролцогчдын 1 хүн буюу 3.3 хувь нь “бараг үгүй”, 12 хүн буюу 40.0 хувь нь “бараг тийм”, 17 хүн буюу 56.7 хувь нь “маргаангүй тийм” гэж хариулжээ (Зураг 3).


**Зураг 3. Семинарын сэдэв танай байгууллагад хамааралтай болон сэдвүүдэд зарцуулсан хугацаа хангалтааг байсан эсэх /хувиар/**



Сэдвүүд хоорондоо уялдаатай байж чадсан уу гэсэн асуултад 40 хувь нь “бараг тийм”, 60 хувь нь “маргаангүй тийм” гэж хариулжээ (Зураг 3).


Үүнээс гадна семинарын үйл ажиллагааг явуулахад ашигласан арга барил болон ашигласан аргууд нь зохимжтой байсан эсэх талаар асуулаа. Бид семинарт олон төрлийн арга ашигласан талаарх хариулт нь дийлэнх буюу 83.3 хувь нь “маргаангүй тийм” гэж хариулсан байхад 6.7 хувь нь “бараг үгүй”, үлдсэн 10 хувь нь “бараг тийм” гэж хариулжээ.

**Зураг 4. Семинарт ашигласан арга, түүний зохимж**



Харин бидний ашигласан арга барил зохимжтой байсан эсэх талаар оролцогчид хариулахдаа 60 хувь нь “маргаангүй тийм”, 36.7 хувь нь “бараг тийм”, 3.3 хувь нь “бараг үгүй” гэж хариулжээ. Бидний ашигласан зарим нэг арга зохимжгүй байсан байж болох талтай юм.

**Зураг 5. Семинарын материал ач холбогдолтой эсэх**




Бидний тараасан семинарын материалууд ач хоблогдолтой эсэх талаар асуухад оролцогчдын мөн л ихэнх нь буюу 21 хүн (70 хувь) “маргаангүй тийм”, 8 хүн (26.7 хувь) “бараг тийм”, 1 хүн (3.3 хувь) “бараг үгүй” гэсэн хариултыг өгчээ (Зураг 5).

Харин оролцогчид бидний сургалтаас шинэ санаа, санаачлага сурсан уу хэмээн асуухад судалгаанд орлцсон 30 оролцогчийн мөн л 70 хувь нь маргаангүй тийм гэсэн хариултыг өгч 26.7 хувь нь бараг тийм, 3.3 хувь буюу өнөөх л 1 хүн бараг үгүй гэсэн хариулт өгсөн байна.

Сургалтын орчны нөхцөл байдлын талаар асуухад тэдний 80.0 хувь нь (24 хүн) маргаангүй тийм гэсэн хариултыг өгсөн байгаа юм.


Семинарын баг өөрсдийн оногдсон ажлаа сайн хийсэн үү? гэж асуухад оролцогчдын 83.3 хувь нь буюу 25 хүн “маргаангүй тийм” хэмээн хариулсан бол 16.7 хувь нь буюу 5 хүн “бараг тийм” гэж хариулжээ.

Зураг 6. Семинарын баг өөрсдийн оногдсон ажлаа сайн хийсэн үү?



Чиглүүлэгч, дэмжих багийн гишүүд сэдвийн талаар хангалттай мэдлэгтэй байсан талаар асууж үзэхэд оролцогчдын 26 хүн буюу 86.7 хувь нь “маргаангүй тийм” гэж хариулсан байхад 4 хүн буюу 13.3 хувь нь “бараг тийм” гэсэн хариулт өгсөн нь хангалттай үзүүлэлт гэж үзэж болохоор байна.

Харин оролцогчийг энэхүү семинарт сууснаар өөрийн дэд төслийг илүү сайн хэрэгжүүлж чадах уу гэж асуухад 1 хүн (3.3 хувь) хариулаагүй, 4 хүн (13.3) “бараг тийм”, 25 хүн “(83.3) “маргаангүй тийм” гэсэн хариултыг өгсөн байна.



Семинарт оролцогчдоос заасан сэдвээс гадна нэмэлтээр НЭХ-ын тухай ямар сэдэв эсвэл ямар асуудлын талаар сурахыг хүсч байгаа талаар асуухад дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд:

- ТББ-ууд хэрхэн төрийн байгууллагатай хамтарч ажиллах талаар хууль, журманд заасан талаар ойлголт, гарын авлага байдаггүй
- Багш нарын хичээлийг авч мэдлэгээ илүү бататгах нь үр дүнтэй байна.
- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хэрэгжүүлж буй төслүүдийн талаарх мэдээллийг бүх хэрэгслүүдээр хүргэх

- Байгууллагын соёл, үнэт зүйл
- Чанарын үнэлгээ аргачлал
- Өгөгдлийг нотлох баримт болгон ашиглах нь сургалтын цагийг боломжтой бол нэмэгдүүлэх нь зүйтэй
- 2 гарын авлагаа бүрэн судална
- Төрийн өндөр албаны хүрээнд НЭХ-г сайжруулах арга
- Гадны орны туршлага судлах
- Иргэдэд, түр оршин суугчдад хандсан мэдээлэл түгээх арга хэрэгсэл. Үйлчлүүлэгчид чиглэсэн нээлттэй бодлого
- Төсвийн хяналт
- Бодлогын нөлөөллийн аргачлалыг илүү дэлгэрэнгүй мэдэх
- Төсвийн орлого бүрдүүлэлтэд иргэд хяналт тавьдаг хууль эрх зүйн үндэслэлийн талаар энгийн, ойлгомжтой мэдлэг, мэдээлэл, чадавхтай болсоноор НЭХ-ийн үр дүн сайн нөлөөлөл үзүүлнэ.

НЭХ-ын өөр ямар аргыг илүү дэлгэрэнгүй судлахыг хүсч байгаа талаар асуухад дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд:

- Хөндлөнгийн үнэлгээ хийх явцад иргэд төслийн үр нөлөөг хэрхэн мэдэрч, хүрч байгааг тооноос болон чанарын түвшинд мэдэх оролцооны аргуудыг судалж, бодит жишээн дээр ажиллах
- Онлайн хичээл орсон сүлжээгээр төдийлөн орж чадаагүй, үүнийг илүү сурах хэрэгтэй байна
- Иргэд олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх механизм
- Хувь хүний үйл ажиллагаанд өөрийн үнэлгээг хийх аргачлал урамшууллын арга. Аливааг сайн талаас нь үнэлж дүгнэх.
- ТББ санхүүжилт босгох арга
- Бусад улсын туршлагыг судлах
- Иргэдийн хяналтын карт, түүний шалгуурууд, үзүүлэлтүүдээс нарийвчлан судалмаар байна
- Олон нийтийн оролцоог хангах чиглэлээр
- Төр хариуцан тайлагнаж, иргэнийхээ өмнө хариуцлагатай баймаар байна. Төрийнхнийг НЭХ-д сургах шаардлагатай
- Энэ удаагийн сургалт нь дэд төслийг илүү үр дүнтэй болгоход маш том дэмжлэг боллоо. Цаашдаа МУ-ын кейс, видео хэлбэрээр туршлагыг үзэж, ажилдаа хэрэгжүүлэхэд хэрэгтэй юмуу гэж бодлоо. Баярлалаа
- ИОК-г ашиглах арга зүй
- Нээлттэй засаглалын талаар илүү мэдэх шаардлагатай. Иргэдийн идэвх оролцоог сайжруулах, хандлагыг өөрчлөх аргад илүү суралцах хүсэлтэй байна
- ИОК-аас бусад аргыг дэлгэрэнгүйгээр
- ИОК-аас өөр илүү хүртээмжтэй цаг, зав хэмнэсэн аргачлал
- Өөр шинэлэг аргад суралцмаар байна
- Заасан аргуудыг ашиглах арга барил дадлага
- Туршлага солилцох